



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04 сарын 25

Дугаар 01

Улаанбаатар хот

"Материалимпэкс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Оюун даргалж, хувьцаа эзэмшигч Б.Зориг /768062/, Д.Тунгалаг /99192/, Д.Оюун /1279/, Д.Төмөр-Очир /5/, Ж.Энхтунгалаг /1/, "Би Ди Сек ҮЦК" ХХК /8512/-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Хулан, Б.Ганболд /1/, С.Мягмарсүрэн /14/, Ж.Энхтунгалаг /1/ нарыг оролцуулан, хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуунаар хөтлүүлэн "Материалимпэкс" ХК-ийн хурлын танхимд 2022 оны 04 сарын 25-ны өдрийн 10 цаг 50 минутад хийв.

Ашигласан цахим хаяг: ZOOM-meeting /847 663 2632/

/Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ч.Энхтуул, Б.Саранцэцэг, Ц.Ариунаа, гишүүн П.Баатарцэрэн, Б.Болортуяа, Б.Батбаатар нар цахимаар оролцсон болно/

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлээд, ХЭ-ийн ээлжит хурлын дэгийг танилцуулаад брокер дилерийн компаниудаар хурлын материал, дэгийг илгээсэн. Одоо оролцож байгаа хүмүүст ч мөн илгээсэн байгаа. Урьдчилан танилцаад асууж тодруулах зүйлээ бэлдээд ирсэн байх. Энэ жилийн ээлжит хурал маань цахим болон танхим хосолсон хэлбэрээр явагдаж байгаа онцлогтой тул дүрс сарних, дуу хоолой тасалдах тохиолдолд та бүхэн даруй мэдэгдэж хурлын явцыг бүрэн мэдэж оролцох шаардлагатай байна.

Хурлаа эхлүүлэхээс өмнө тооллогын комиссын гишүүдээ танилцуулъя гээд Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэл нягтлан бодогч мэргэжилтэй, "Материал Гласс" ХХК-ийн нягтлан бодогч ажилтай, П.Сумъяасугар тус компанийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст тээврийн менежерээр ажилладаг, манай компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй ямар нэгэн садан төрлийн болон ашиг сонирхлын зөрчилгүй, манай компанийн хувьцаа эзэмшдэггүй, тооллогын комиссын гишүүн П.Сувдаа тус компанийн Гаалийн хяналтын бүсэд пүүлэгчээр ажилладаг, тооллогын комиссын гишүүд бүгдээрээ манай компанийн хувьцаа эзэмшдэггүй. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Одоо цаг 10 цаг 50 минут болж байна, комиссын дарга, гишүүд ирцийн бүртгэлийг дуусгаж, ирцийн мэдээгээ танилцуулъя.

Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч нэгбүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийв. Ирцийн ажиллагаа 10:10 цагаас эхэлсэн болно.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Ирцийн мэдээллийг хуралд танилцуулж, 877,568 ширхэг саналын эрх бүхий хувьцаатай 8 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна. Ирцийн дүн 64,13% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын дараалал, хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Тооллогын комисс ирцийн бүртгэлээ хийж, ирцийн мэдээгээ танилцууллаа
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах

- Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах
- ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин урамшуулал, үйл ажиллагааны төсвийн талаар хэлэлцүүлэх, батлах

- Ногдол ашгийн хуваарилалтын талаар мэдээлэл, тайлбар сонсох
- Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариултыг тухай бүрт
- Тооллогын комиссоос, саналын хуудсыг бөглөх зааврыг өгч санал хураалт явагдана.

- Саналын хуудас тоолох явцад хурал түр завсарлана.
- Тооллогын комиссоос саналын хуудасны дүнг танилцуулна.
- ХЭХ-аас гарах тогтоолыг танилцуулж, батлуулна.
- Хурлыг хаана. Ийм дарааллаар өнөөдрийн хурал явагдана.

Хэлэлцэх асуудлын дараалал болон бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдэд асуух болон хэлэх санал хүсэлт байна уу? Хурлын материалыг Монголын Хөрөнгийн Бирж болон өөрийн сайтдаа байршуулсан, үнэт цаасны компаниуд руу мэйлээр явуулсан. Өдрийн сонинд 2022.03.18 болон 2021.04.01-ний өдрүүдэд хурлын зар байршуулсан байгаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг нийтэд мэдээлснээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд компани дээр хурлын материалыг хэвлэж бэлдсэн байсан боловч хэн ч ирж танилцаагүйг тэмдэглэлд мөн тусгуулъя. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаас өмнө шаардлагатай материалтайгаа ирж танилцах бүрэн боломж үргэлж нээлттэй байдаг гэдгийг дахин хэлье. Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэн хэлэлцэх асуудал тус бүрт чөлөөтэй, идэвхтэй асууж, хариулж, сонирхсон бусад зүйлсээ минут харгалзахгүйгээр чөлөөтэй асууж болно.

Оролцогчид: Дараалал, хурлын материалтай танилцсан тул хэлэлцэх асуудалд оруулах саналгүй, асуулт хариултын журмаар явуулахыг дэмжиж байна гэцгээв.

Даргалагчаас: Хурлын зарыг СЗХ-оос шинэчлэн батлагдсан журмын дагуу хийж гүйцэтгэсэн. За ингээд хэлэлцэх асуудлын дарааллын талаар асуух асуулт байхгүй бол нэг дэх асуудалдаа оръё. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг миний бие хэлэлцүүлнэ. /ТУЗ-ийн дүгнэлтийг хавсаргав/.

Даргалагчаас: Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтээс асуух асуулт байна уу?

Б.Ганболдоос: ТУЗ-өөс компанийг сайн ажилласан гэж дүгнэж байна уу?

Даргалагчаас: Тийм ээ, цар тахлын хүнд хэцүү нөхцөлд компани 5,1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байхад муу гэж дүгнэх үндэслэл байхгүй. Маш сайн гэж хэлж болно.

Бусад оролцогчдоос: Асуух асуулт байхгүй гэв.

Даргалагчаас: Асуултаа хэдийд ч тавьж болно шүү. Дараагийн хэлэлцэх асуудал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг аудитын хорооны гишүүн П.Баатарцэрэнгээс хэлэлцүүлнэ.

П.Баатарцэрэнгээс: Аудитын хорооны дүгнэлтийг уншиж хэлэлцүүлэв.

Ж.Энхтунгалагаас: Дансны авлага хэдээр буурсан байсан бэ?

П.Баатарцэрэнгээс: 719 саяар буурсан байгаа гэв.

С.Мягмарсүрэнгээс: Авлага барагдуулах тал дээр их хичээж ажиллаж байгаа гэж харагдаж байна?

П.Баатарцэрэнгээс: Тийм гэв.

С.Мягмарсүрэнгээс: Борлуулалтын орлого өсөхөд ямар төрлийн бараа материалын борлуулалт нөлөө их үзүүлсэн бэ?

П.Баатарцэрэнгээс: Арматурын борлуулалт гэв.

Б.Ганболдоос: 2021 онд цементийн борлуулалт ерөөсөө хийгээгүй юм уу?

П.Баатарцэрэнгээс: Тийм, 2021 оны тухайд цементийг гэрээ хийж чадаагүй, дотоодын үйлдвэрүүд бага хэмжээгээр үйлдвэрлэснээ үйлдвэрээсээ борлуулаад гэрээт борлуулагчаар бараг дамжуулаагүй. Энэ жилийн хувьд ч одоогийн байдлаар хийгдсэн гэрээ байхгүй, уулзалт, ярилцалагын түвшинд л байгаа гэв.

Б.Ганболдоос: Цементийн тээвэр чухал байх л даа, төмөр замын дотоод үйлчилгээ, үнэ тариф нэмэгдсэн үү?

П.Баатарцэрэнгээс: Бүгд нэмэгдсэн гэв.

Б.Ганболдоос: Өглөг гэж ямар ямар өр төлбөр байгаа вэ?

П.Баатарцэрэнгээс: Манайх зээл болон урт хугацаат ямар нэгэн өр төлбөр байхгүй, энэ балансад тусгагдсан өглөг дансны өглөг бол чингэлгийн өглөг байгаа. Чингэлэг маань өөрөө гадаадаас гарах үеэс эхлэн санхүүгийн хувьд бүртгэл хийгдэж эхэлдэг учраас өглөг, авлага дансад зэрэг бүртгээд чингэлгээ буцаахдаа хаалтаа хийж явдаг байгаа. Энэ чингэлгийн өр төлбөр гэж ойлгож болно гэв.

С.Мягмарсүрэнгээс: Шинээр орсон барилга гэж аль барилгыг хэлээд байна?

Д.Оюунаас: Энэ бидний одоо хурал хийж байгаа офиссын барилгыг улсын комисст хүлээлгэн өгсөн тул барилга дансанд бүртгэгдсэн байгаа гэв.

Б.Ганболдоос: Зээлийн хүү ер нь өссөн үү?

П.Баатарцэрэнгээс: 2021 онтой харьцуулахад өсөөгүй, буусан байгаа гэв.

Б.Ганболдоос: Материалимпэкс ХК ямар банкнаас зээл авдаг вэ?

П.Баатарцэрэнгээс 2021 онд Хаан банкнаас авсан, ер нь бол бүх л банктай харилцаа холбоотой байдаг гэв.

С.Мягмарсүрэнгээс: Одоо энэ баригдаж байгаа үйлчилгээний төвийн барилга хэзээ ашиглалтад орох вэ?

Даргалагчаас: Бидний 2022 оны төлөвлөгөөнд бол 2022 оны 2-р улирал гэсэн байгаа. Бид аль болох ашиглалтад хурдагн оруулах хүсэлтэй хэдий ч биднээс шалтгаалахгүй олон нөхцөл байдал үүсэх магадлалтай тул яг тэдийд эдийд гэж одоо хэлэх нь арай эрт байна. ямар нэгэн саад бэрхшээл гарахгүй л бол бид хугацаанд нь ашиглалтад хүлээлгэж өгөхөөр ажиллаж байгаа.

Б.Ганболдоос: Бараа материалын татан авалт хэр удаж байна вэ?

П.Баатарцэрэнгээс: Ердийхөөс 2-3 дахин илүү хугацаа зарцуулж байгаа гэв.

Б.Ганболдоос: Бараа материалаа өөрсдөө оруулж ирдэг үү?

П.Баатарцэрэнгээс: Тийм, манайх элсэн чихэр, арматураа өөрсдөө импортоор оруулж ирдэг гэв.

С.Мягмарсүрэнгээс: Энэ баригдаж байгаа барилгын хэмжээ хэд орчим бол?

Б.Зоригоос: 10,000 орчим м.кв байгаа гэв.

С.Мягмарсүрэнгээс: Одоогийн байдлаар хэчнээн төгрөгийн хөрөнгө оруулалтыг энэ барилгад оруулсан байгаа вэ?

Б.Зоригоос: 6,3 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байгаа гэв.

С.Мягмарсүрэнгээс: Үйлчилгээний төвд ийм ийм үйл ажиллагаа явуулна гэсэн чиглэлээ тодорхойлсон байгаа юу?

Б.Зоригоос: Судалгааны түвшинд явж байгаа, яг тийм ийм гэсэн зүйл одоогоор байхгүй байна гэв.

С.Мягмарсүрэнгээс: Энэ барилга балансад ямар дансанд бүртгэгдсэн байгаа вэ?

П.Баатарцэрэнгээс: Урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэгдсэн байгаа, улсын комисс ажилласны дараа үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гарсан үед барилга байгууламж данс руу шилжинэ гэв.

С.Мягмарсүрэнгээс: Хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэ гэсэн дарамт шахалт хэр байна?

Даргалагчаас: Дарамт шахалт ч юу байх вэ, бид өөрсдөө үнэлгээг дахин хийлгэх сонирхол байдаг, гэхдээ өртөг өндөртэй учраас жил бүр хийлгээд байж чаддаггүй. Ер нь бол 2-3 жил тутамдаа хийлгэж байна. сүүлийн 2 жил бол хийлгээгүй байгаа гэв.

Даргалагчаас: Нэмж асуух асуулт байвал байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх дараагийн асуудалдаа оръё. Гүйцэтгэх захирлаас 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлье.

Б.Зоригос: 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлэв. /тэмдэглэлд хавсаргав/
Асуух асуулт байвал хариулъя.

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Өмнөх хэлэлцсэн асуудлуудтай холбоотой болон төлөвлөгөөтэй холбоотой асууж тодруулах зүйл, санал байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудлын дараалал ёсоор Ногдол ашгийн талаарх мэдээллийг Б.Саранцэцэг гишүүнээс мэдээлэл өгнө.

Б.Саранцэцэгээс: 2021 онд манай байгууллага санхүүгийн тайлангаар 5,1 тэрбус төгрөгийн ашигтай ажилласан учраас энэ жил нэгж хувьцаанд 230 төгрөгийн ногдол ашиг тараахаар ТУЗ-ийн тогтоол гарсан байгаа. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хөрөнгөөр, бусад хувьцаа эзэмшигчдэд Үнэт цаасны төвөөр дамжуулан мөнгөн хэлбэрээр тараах болсон байгаа гэв.

Даргалагчаас: Ногдол ашигтай холбоотой сууж тодруулах зүйл, санал байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, төсөвийг хэлэлцүүлье. 2022 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны бичиг хэргийн зардалд 5,000,000 төгрөг, дарга, гүйцэтгэх захирлын цалин хөлс, ердийн болон хараат бус гишүүн, нарийн бичгийн даргын цалин хөлс 97,200,000 төгрөг, идэвхийн урамшуулалд 8,000,000 төгрөг төсөвлөсөн. Энэхүү урамшууллыг гэхдээ заавал олгохгүй, ямар үед олгох вэ гэхээр гишүүдийн хуралд оролцох оролцоо, идэвх, санаачлага, компанид ашигтай ажиллагааг хэрэгжүүлсэн тохиолдолд олгож болох юм гэсэн санаагаар төсөвт оруулж байгаа юм.

Харин гүйцэтгэх захиралд энэ жил урамшуулал олгох саналыг цалин урамшууллын хороо гаргаж, аудитын хороо дэмжиж, ХЭХ-д хэлэлцүүлж байгаа юм.

Б.Зориг захирал 1999 оноос одоог хүртэл энэ компанийг удирдаж байгаа, ашиг орлоготой үе ч бий, ашиггүй ажиллах үе ч их байсан, гэхдээ ашигтай ажилласан жилүүд нь илүүтэй. Мөн өнөөдрийг хүртэл энэ компанийг оршин тогтнож, тогтвортой үйл ажиллагаагаар хангаж, зарж бутаргалгүй өдий дайны авч яваа нь гарцаагүй Б.Зориг захирлын үр чадвар, хичээл зүтгэл мөн. 1999 оноос хойшхи түүхэнд манай байгууллага нэг ч удаа гүйцэтгэх удирдлагаа урамшуулж байсан түүхгүй, энэ талаар өмнөх өмнөх ТУЗ-ийн гишүүд санал санаачлага гаргадаг байсан ч захирал өөрөө татгалздаг, шалтаг хэлдэг байдлаар хойшилсоор ирсэн. Цар тахлын хүнд хэцүү үед зөв зохион байгуулалт хийж, компанийг 5,1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллуулсан гүйцэтгэх захирлыг 200,000,000 төгрөгөөр урамшуулах саналыг ЦУХ-оос хэлэлцүүлж байгаа юм. Гэхдээ энэ урамшууллыг заавал мөнгөн хэлбэрээр олгохгүй, хөрөнгөөр олгож болох юм, баригдаж байгаа барилга, барьсан барилга, бартерт ирсэн байр сууц гээд хөрөнгөөр олгож болох олон хувилбар боломж байгаа юм. Энэ талаар эрхэм хувьцаа эзэмшигчид маань саналаа хэлнэ үү.

Бүх гишүүд: 100%-ийн саналаар дэмжив. Татгалзах болон тодруулах зүйл байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцсэн асуудлуудтай холбоотой асууж, тодруулах зүйл байна уу?

Оролцогчид: Өөр асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудал, мэдээллийн чанартай сонсох асуудлууд дууслаа. Хувьцаа эзэмшигчдэд асуух асуулт байна уу? Асуулт хариултдаа орцгооё.

Оролцогчид: Асуух асуулт байхгүй гэв.

Даргалагчаас: Санал хураалтдаа орьё. Тооллогын комиссоос саналыг хуудсыг тараая.

Тооллогын комиссын гишүүдээс хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас тарааж, бөглөх зааврыг танилцуулав.

Санал хураалт 11:50 цагт эхлэв.

Хурал 11:50 цагт завсарлаж, 12:50 цагт үргэлжлэв.

Даргалагчаас: Тооллогын комиссын дүн гартал та бүхний сонирхсон асуулт, санал, зөвлөгөөг сонсьё.

Б.Ганболдоос: Ер нь сүүлийн жилүүдэд байгууллагууд зээл авахаасаа илүүтэй бонд гаргах, нэмж хувьцаа гаргах хэлбэрээр хөрөнгө босгож байгааг бас та бүхэн анзаарч анхаарч байгаа байх аа. Мөн ХК-иуд улирал бүр тайлан гаргаж, ил тодын зарчмыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ тал дээр мөн анхаарч илүү сайн ажиллахыг хүсье. Залуу хүний эрч хүч харагдаж байна, сайн ажилласан байна гэв.

С.Мягмарсүрэнгээс: Бизнес төлөвлөгөөндөө тоо тавьсан бол илүү үр дүнтэй байх байсан болов уу гэж санагдаа. Гэхдээ сайн ажиллаж, ногдол ашиг тарааж, ашигтай ажиллаж байгаа хамт олонд талархах нь зүйтэй. Амжилт хүсэж байна гэв.

Ж.Энхжаргалаас: Би хувьдаа бол үйл ажиллагаагаа маш сайн явуулсан байна гэж харж, дүгнэж байна. ХЭЭХ-даа байнга идэвхитэй оролцдог жижиг хувьцаа эзэмшигч цөөн байдаг, энэ талаар та бүхэн бас бодолцох байх аа гэж найдаж байгаа шүү гэв.

Бусад оролцогчидоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцсэн асуудлуудтай холбоотойгоор нэмж гаргах санал, хүсэлт, асуулт байна уу?

Бусад оролцогчид: Асуух асуултгүй, нэмж хэлэх санал байхгүй байна гэв.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Тооллогын дүнгийн тухай комиссын тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

Саналын хуудаснуудыг шалгахад 8 хуудаснаас 8 хуудсыг хүчинтэйд тооцож,

Хүчинтэйд тооцогдсон саналын хуудсаар дүгнэхэд хэлэлцүүлж буй асуудлыг доорхи хувиар зөвшөөрснийг тогтоов. Үүнд :

Компанийн 2021 үйл ажиллагааны болон санхүүгийн байдалд хийсэн ТУЗ-ийг дүгнэлтийг зөвшөөрсөн 100 хувь

Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрсөн 100 хувь

Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг зөвшөөрсөн 100 хувь

ТУЗ-ийн төсөв баталсан 100 хувь

Даргалагчаас: Тооллогын комиссын дүнтэй холбоотой асуух асуулт байна уу?
Оролцогчдоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг үндэслээд өнөөдрийн ХЭХ-аас дараах тогтоолууд гарч байна. Тогтоол №01 утга:

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх

Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталж, Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгаад,

Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгов.

Тогтоол №02. Утга:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээ, 2022 оны үйл ажиллагааны нийт төсвийг 310,200,000 /Гурван зуун арван сая хоёр зуун мянган/ төгрөгөөр баталж,

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, төсвийг үр ашигтай захиран зарцуулахыг үүрэг болгов.

Даргалагчаас: Хурлаас гарч буй тогтоолыг ХЭ-дээсээ гар өргөж давхар баталгаажуулъя. Тогтоол №01, 02, 03-ыг батлах уу?

Бүх гишүүд: 100% гар өргөн батлав.

Даргалагчаас: Ингээд хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 12 цаг 25 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА

Т.ЛХАГВАЧУЛУУН

Д.ОЮУН